




2026 оны 8. дугаар сарын 28-ны өдөр

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад “төсөв” гэж төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогц гэж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтад “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл” гэж тухайн төсвийн жилийн хүлээгдэж байгаа макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төсвийн бодлогын баримт бичиг гэж, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх гэж тус тус заасан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг Улсын Их Хурал 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталсан.

Тус хууль батлагдсанаас хойш Татварын багц хуулийн шинэчилсэн зохицуулалт болон нийгмийн даатгал, нийгмийн салбарын холбогдох хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд 2027 оны төсвийн жилээс хэрэгжихтэй

холбоотойгоор төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ батлагдсан дүнгээс 1 их наяд төгрөгөөр дутахаар байгаа нь төсвийн орлого, зарлага болон төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан үндсэн үзүүлэлтүүдийг шинэчлэн тооцох шаардлага үүсээд байна.

Төсвийн орлогын баазыг нэмэгдүүлэх, төсвийн тогтвортой байдлыг хангах хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглал, ашигт ажиллагаа, санхүүгийн сахилга батыг сайжруулж, хөрөнгийн өгөөж, төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг, орлогыг нэмэгдүүлэх, төрийн өмчийн хувьцаа, хөрөнгийн удирдлагыг боловсронгуй болгох бодлогын арга хэмжээний төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцон, төсвийн орлогын шинэчилсэн тооцоонд тусгах шаардлагатай байна.

Мөн Оюу Толгой төслөөс 2027 онд Монгол Улсын Засгийн газрын буюу төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогоос 3,000.0 тэрбум төгрөг төсөвт төвлөрөхөөр төсөөлж байгаа бөгөөд үүнээс нийгмийн өмнө тулгамдсан суурь асуудлууд болон эрчим хүч, бусад дэд бүтцийн салбарын санхүүгийн хүндрэлийг үе шаттай арилгах, хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай хөрөнгийн дутагдлыг шийдвэрлэхээр тооцоолж байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд уг хуулийн төсөлд төсвийн тусгай шаардлагыг өөрчлөн, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл батлагдсанаас хойш уг мэдэгдлийг боловсруулахад тооцох боломжгүй нөхцөлөөс шалтгаалан ногдол ашгийн орлого, орон нутгийн үнэт цаас, урьд оны үлдэгдлээс хамаарсан эх үүсвэр нэмэгдсэнтэй холбоотойгоор нэмэгдсэн орлогын хэмжээгээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.1.4-т заасан нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг нэмэгдүүлэн тооцож болно. Энэ тохиолдолд уг нэмэгдлийн хэмжээнд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлага хамаарахгүй байх зохицуулалтыг тусгасан.

Иймд дээр дурдсан хууль тогтоомжийн өөрчлөлт, тэдгээрийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, төсвийн орлогын шинэчилсэн тооцоо болон макро эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан төсвийн орлого, зарлага, төсвийн тэнцэл болон 2027-2029 оны төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг шинэчлэн тогтоох шаардлага үүсэж байгаа тул Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн үндсэн үзүүлэлтүүдийг макро эдийн засгийн шинэчилсэн төсөөлөл, гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэн тогтооход орших бөгөөд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг хүснэгтээр батлахтай холбогдсон зохицуулалтыг тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан макро эдийн засаг, төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг эдийн засгийн шинэчилсэн нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэн тооцож, 2027 оны төсвийн тухай хуулийн төслийг бодит тооцоо, үндэслэлтэйгээр төлөвлөх, улсын төсвийн хөрөнгийг үр ашигтай, оновчтой хуваарилах, төсвийн бодлогыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

---o0o---